



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чингис хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112 Цахим хуудас: www.audit.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Ахлах аудитор: Н.Туяа Утас: 99799709 Аудитор: Ц.Нарангэрэл Утас: 99028942
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг khentii@audit.gov.mn хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.04 № 82
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Н.НЯМХАТАН ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа, аудитор Ц.Нарангэрэл нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд “Манай байгууллага 2030 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий ДААТГАГЧ болно” гэсэн хэтийн зорилтыг тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын хяналт шалгалтын газраас болон хяналт, шалгалт дотоод аудитын тасгаас 2021 онд Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн сангийн үйл ажиллагаа болон үндсэн үйл ажиллагааны санхүүд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 75 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 63,475.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 634.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 476.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,332,978.6 мянган төгрөгөөр буюу 12 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,476,356.9	6,945,966.6	469,609.7
Авлага	4,269,609.1	5,175,507.8	905,898.7
Урьдчилгаа			-
Бараа материал	9,840.8	10,219.4	378.6
Үндсэн хөрөнгө	368,606.8	325,698.4	(42,908.4)
Нийт хөрөнгө	11,124,413.6	12,457,392.2	1,332,978.6
Өр төлбөр	267,108.2	265,115.7	(1,992.5)
Засгийн газрын оруулсан капитал	284,367.3	284,367.3	-
Хуримтлагдсан үр дүн	10,562,191.1	11,897,162.2	1,334,971.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747.0	10,747.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,124,413.6	12,457,392.2	1,332,978.6

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,476.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6,946.0 сая төгрөг болж 469.6 сая төгрөгөөр өссөн. Мөнгөн хөрөнгийн 2.4 сая төгрөг төрийн сан дахь ахмадын сангийн харилцах дансанд, 1.1 сая төгрөг төрийн сан дахь ерөнхий орлогын дансанд, 6,942.5 сая төгрөг арилжааны банкны дансанд байршиж үлдэгдэлтэй гарчээ.

Авлага дансны эхний үлдэгдэл 4,269.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,175.5 сая төгрөг болж, 905.9 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

Төлбөртэй үйлчилгээний авлага дансны үлдэгдэлд 172 ажил олгогчийн 586.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Татаас санхүүжилтийн 4,521.7 сая төгрөг авлагад 630 ажил олгогчийн 2,817.4 сая төгрөг, 4059 сайн дурын даатгуулагчийн 1,513.1 сая төгрөгийн чөлөөлөгдсөн шимтгэлийн авлага, 956 даатгуулагчийн 191.2 сая төгрөгийн ажилгүйдлийн даатгалын сангаас олгосон дэмжлэгийн авлага зэрэг улсын төсвөөс авах авлага байна.

Бусад авлага дансны 67.4 сая төгрөгийн үлдэгдэлд 53.7 сая төгрөгийн улсын байцаагчийн актаар тавигдсан тэтгэвэр, тэтгэмжийн авлага, 13.7 сая төгрөгийн илүү олгосон тэтгэвэр тэтгэмжийн авлага байна.

Өнгөрсөн оны эцсийн 50.4 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй авлагаас 29.5 сая төгрөгийн авлага барагдаж, 20.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлагын үлдэгдэлд 4-5 жилийн насжилттай 34.7 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 9.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 10.2 сая төгрөг болж, 0.4 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, шатах тослох материалын үлдэгдэл өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл нь 598.7 сая, эцсийн үлдэгдэл 606.1 сая төгрөг болж, 7.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 8.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн, хандиваар 4.4 сая төгрөг, нийт 12.3 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, 4.9 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 267.1 сая, эцсийн үлдэгдэл 265.1 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 81.1 сая төгрөгийн олгогдоогүй тэтгэмж, тэтгэвэр, 10.8 сая төгрөгийн бусад өрийн үлдэгдэл байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд урьдчилж орсон нийгмийн даатгалын шимтгэлийн орлого байна. Үүнд: Ажил олгогчийн 114.9 сая төгрөг, сайн дурын даатгуулагчийн 58.3 сая төгрөг, нийт 173.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 11,897.2 сая төгрөг болж 1,335.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлжээ.

Аймгийн Нийгмийн даатгалын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 32,250.8 сая төгрөгөөр буюу 31.4 хувиар буурсан байна. Үйл ажиллагааны орлого нь 70,461.1 сая төгрөг болж буурсан нь хүүгийн орлого, төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх орлого, нийгмийн даатгалын сангаас санхүүжих орлого, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих, төвлөрүүлэх шилжүүлэг, бусад орлого буурсантай холбоотой байна.

Тайлант оны нийт зардал 69,126.1 сая төгрөг болж өмнөх оноос 26,242.0 сая төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан байна. Үүнд үндсэн үйл ажиллагааны урсгал зардалд 775.9 сая төгрөг, тусгай санд 68,350.2 сая төгрөгийн зардал гарган үйл ажиллагаа явуулжээ.

Тусгай сангийн төвлөрүүлэх шилжүүлгийн зардал өмнөх оноос 29,511.7 сая төгрөгөөр буурсан нь зардлын бууралттай холбоотой байна. Өмнөх оноос нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал 3,292.3 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардал 3.8 сая төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай 22 дугаар тогтоолд зааснаар Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын сан тайлант онд 31,761.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117.8 хувиар биелүүлсэн байна

Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн даатгалын сан	23,558.6	26,832.3	(3,273.7)	114%
Тэтгэмжийн даатгалын сан	1,818.2	2,328.1	(509.9)	128%
ҮОМШӨ-ний даатгалын сан	1,193.8	2,110.4	(916.6)	177%
Ажилгүйдлийн сан	395.2	490.4	(95.2)	124%
Нийт дүн	26,965.8	31,761.1		117,8%

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд нийгмийн даатгалын сангийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 24,123.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 65,565.5 сая төгрөгөөр, үйл ажиллагааны урсгал төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр, зардлыг 1,154.6 сая төгрөгөөр тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс санд төвлөрүүлэх орлогыг 2,842.2 сая төгрөгөөр өсгөж 26,965.8 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн зарлагыг 4,819.3 сая төгрөгөөр бууруулж, 60,746.2 сая төгрөгөөр баталсан байна. Урсгал үйл ажиллагааны төсвийг 394.6 сая төгрөгөөр бууруулж 760.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 61,506.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 760.0 сая төгрөгийг урсгал зардалд, 60746.2 сая төгрөгийг санд зарцуулахаар батлагдсан.

Гүйцэтгэлээр нийт 31,761.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, дээд шатны төсвийн захирагчаас 31,370.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын сангийн санхүүжилт, 760.0 сая төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авчээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 68.4 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 0.4 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 60,908.6 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь урсгал үйл ажиллагааны зардал 37.3 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг /нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж/ 560.3 сая төгрөгөөр хэмнэгдсэнээс шалтгаалсан байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 33.6 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Үүнд: 11 сар хүртэл жолоочийн орон тоо сул байсан, мөн 3 сараас эхлэн жижүүр, 4 сараас эхлэн хяналт шалгалт дотоод аудитын тасгийн дарга эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөтэй байсан учир цалин хэмнэгджээ. Урсгал санхүүжилтээс хэмнэгдсэн 37.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна..

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, сургалт семинарын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг болон бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийт мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн боловч нийгмийн даатгалын сангийн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудалд өгсөн 1 албан шаардлага өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нийгмийн даатгалын хэлтэс	0	0	0	0	0	0	0	0	0	0

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,755,806,877.85	12,131,693,819.43
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,476,356,878.73	6,945,966,585.89
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,476,356,878.73	6,945,966,585.89
4	Төгрөг	6,476,356,878.73	6,945,966,585.89
5	Төрийн сангийн харилцах	6,894,411.69	3,476,650.75
6	Арилжааны банк дахь харилцах	6,469,462,467.04	6,942,489,935.14
7	АВЛАГА	4,269,609,150.12	5,175,507,792.14
8	Төлбөртэй үйлчилгээний авлага	453,022,065.55	586,423,590.69
9	Татаас, санхүүжилтийн авлага	3,800,136,301.97	4,521,716,877.97
10	Бусад авлага	16,450,782.60	67,367,323.48
11	Байгууллагаас авах авлага	16,450,782.60	67,367,323.48
12	БАРАА МАТЕРИАЛ	9,840,849.00	10,219,441.40
13	Хангамжийн материал	9,840,849.00	10,219,441.40
14	Бичиг хэргийн материал	48,000.00	1,199,100.00
15	Аж ахуйн материал	4,210,700.00	3,937,000.00
16	Сэлбэг хэрэгсэл	0	1,043,100.00
17	Түлш, шатах тослох материал	1,147,762.00	2,824,799.00
18	Бусад хангамжийн материал	4,434,387.00	1,215,442.40
19	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	368,606,790.13	325,698,361.46
20	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	368,606,790.13	325,698,361.46
21	Биет хөрөнгө	347,956,790.13	305,048,361.46
22	Барилга, байгууламж, орон сууц	283,639,655.00	283,639,655.00
23	Хуримтлагдсан элэгдэл	-33,275,565.97	-45,267,444.19
24	Авто-тээврийн хэрэгсэл	89,980,000.00	89,980,000.00
25	Хуримтлагдсан элэгдэл	-69,984,444.44	-84,981,111.11
26	Машин тоног төхөөрөмж(компьютер)	127,972,405.38	135,413,102.38
27	Хуримтлагдсан элэгдэл	-78,740,062.86	-95,207,593.64
28	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,930,500.00	68,930,500.00
29	Хуримтлагдсан элэгдэл	-40,565,696.98	-47,458,746.98
30	Биет бус хөрөнгө	20,650,000.00	20,650,000.00
31	Програм хангамж	7,504,571.00	7,504,571.00
32	Хуримтлагдсан элэгдэл	-7,504,571.00	-7,504,571.00
33	Бусад биет бус хөрөнгө	20,650,000.00	20,650,000.00
34	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,124,413,667.98	12,457,392,180.89
35	НИЙТ ӨР ТӨЛБӨР	267,108,229.57	265,115,671.06
36	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	267,108,229.57	265,115,671.06
37	Өглөг	153,812,164.14	91,947,333.79
38	Бараа үйлчилгээний зардлын өглөг	153,812,164.14	91,947,333.79
39	Урьдчилж орсон орлого	113,296,065.43	173,168,337.27
40	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	113,296,065.43	173,168,337.27
41	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,857,305,438.41	12,192,276,509.83
42	Засгийн газрын хувь оролцоо	10,857,305,438.41	12,192,276,509.83
43	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	284,367,256.89	284,367,256.89
44	Хуримтлагдсан үр дүн	10,562,191,133.52	11,897,162,204.94
45	Өмнөх үеийн үр дүн	3,215,963,456.32	10,562,191,133.52
46	Тайлант үеийн үр дүн	7,346,227,677.20	1,334,971,071.42
47	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,747,048.00	10,747,048.00
48	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,124,413,667.98	12,457,392,180.89

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	102,711,871,044.87	70,461,082,750.47
2	ТАТВАРЫН ОРЛОГО	35,334,467,002.99	38,190,579,510.44
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	35,334,467,002.99	38,190,579,510.44
4	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,021,653,580.53	27,129,084,323.38
5	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,437,477,098.97	2,537,009,107.08
6	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,178,154,833.74	2,301,722,770.36
7	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	444,370,496.67	479,758,631.34
8	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,252,810,993.08	5,743,004,678.28
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,990,161.63	129,494,299.04
10	Нийтлэг татварын бус орлого	147,990,161.63	129,494,299.04
11	Хүүгийн орлого	134,361,132.77	9,827,246.41
12	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,958,061.86	17,241,555.56
13	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,267,161.86	16,877,555.56
14	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	690,900.00	364,000.00
15	Бусад орлого	2,670,967.00	97,793,083.07
16	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	4,392,414.00
17	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	240,000.00
18	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67,229,413,880.25	32,141,008,940.99
19	Улсын төвлөрсөн төсвөөс	191,200,000.00	0
20	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	191,200,000.00	0
21	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,728,000.00	455,100.00
22	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,728,000.00	285,000.00
23	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	170,100.00
24	Төсвийн захирагчдаас	66,249,292,980.25	31,380,474,040.99
25	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,249,292,980.25	31,380,474,040.99
26	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	785,192,900.00	760,079,800.00
27	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	785,192,900.00	760,079,800.00
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	95,368,113,347.67	69,126,111,679.05
29	УРСГАЛ ЗАРДАЛ	95,368,113,347.67	69,126,111,679.05
30	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	772,174,748.69	775,948,621.17
31	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,633,801.00	549,265,899.10
32	Үндсэн цалин	427,827,597.00	427,161,744.10
33	Нэмэгдэл	89,600,204.00	94,156,155.00
34	Унаа хоолны хөнгөлөлт	19,566,000.00	19,308,000.00
35	Урамшуулал	8,640,000.00	8,640,000.00
36	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,984,030.20	72,049,624.95
37	Тэтгэврийн даатгал	44,839,109.81	49,851,135.51
38	Тэтгэмжийн даатгал	5,539,579.30	5,547,821.12
39	ҮОМШӨ-ний даатгал	4,427,644.40	4,438,256.90
40	Ажилгүйдлийн даатгал	1,105,236.50	1,109,564.22
41	Эрүүл мэндийн даатгал	11,072,460.19	11,102,847.20
42	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,394,743.37	28,878,500.00
43	Гэрэл, цахилгаан	4,250,000.00	3,950,000.00
44	Түлш, халаалт	23,113,000.00	23,113,000.00
45	Цэвэр, бохир ус	2,031,743.37	1,815,500.00
46	Хангамж, бараа материалын зардал	29,999,155.71	24,658,220.85
47	Бичиг хэрэг	6,672,400.00	4,865,300.00
48	Тээвэр, шатахуун	12,009,440.00	10,796,263.00
49	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,471,149.71	2,671,757.85
50	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	814,000.00
51	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,496,166.00	5,510,900.00
52	Эд хогшил, урсгал засварын зардал	1,333,400.00	1,627,000.00
53	Багаж, техник, хэрэгсэл	1,126,100.00	627,000.00
54	Урсгал засвар	207,300.00	1,000,000.00
55	Томиллолт, зочны зардал	2,292,500.00	1,834,700.00
56	Дотоод албан томиллолт	2,292,500.00	1,834,700.00

57	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,195,560.08	40,079,880.60
58	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,570,808.48	26,079,600.00
59	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
60	Даатгалын үйлчилгээ	630,510.00	650,000.00
61	Тээврийн хэрэгслийн татвар	78,100.00	79,500.00
62	Газрын төлбөр	20,650.00	20,650.00
63	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,326,210.00	6,677,860.00
64	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,569,281.60	3,572,270.60
65	Бараа үйлчилгээний бусад зардал	56,341,558.33	57,554,795.67
66	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	2,274,122.00
67	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,091,558.33	55,280,673.67
68	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,595,938,598.98	68,350,163,057.88
69	Бусад урсгал шилжүүлэг	56,856,688,356.00	60,122,634,467.00
70	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	56,818,662,490.00	60,111,037,167.00
71	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,384,166.00	11,597,300.00
72	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,641,700.00	0
73	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,739,250,242.98	8,227,528,590.88
74	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,739,250,242.98	8,227,528,590.88
75	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,343,757,697.20	1,334,971,071.42
76	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,469,980.00	0
77	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,469,980.00	0
78	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,346,227,677.20	1,334,971,071.42

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	99,546,395,690.07	69,642,911,102.06
2	ТАТВАРЫН ОРЛОГО	32,211,072,750.24	37,367,527,185.83
3	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	32,211,072,750.24	37,367,527,185.83
4	Тэтгэврийн даатгалын шимтгэл	22,496,778,746.47	26,768,023,611.29
5	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,116,501,862.72	2,322,038,894.92
6	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,872,767,792.23	2,104,811,144.34
7	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	403,739,395.02	440,578,478.23
8	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,321,284,953.80	5,732,075,057.05
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	339,828,752.16	97,654,816.23
10	Нийтлэг татварын бус орлого	339,828,752.16	97,654,816.23
11	Хүүгийн орлого	134,361,132.77	9,827,246.41
12	Төсөв байгууллагын өөрийн орлого	205,467,619.39	87,827,569.82
13	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	204,776,719.39	87,463,569.82
14	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	690,900.00	364,000.00
15	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	66,995,494,187.67	32,177,729,100.00
16	Улсын төвлөрсөн төсвөөс	0	47,194,200.00
17	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	47,194,200.00
18	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,728,000.00	455,100.00
19	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,728,000.00	285,000.00
20	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	170,100.00
21	Төсвийн захирагчдаас	66,206,573,287.67	31,370,000,000.00
22	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,206,573,287.67	31,370,000,000.00
23	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	785,192,900.00	760,079,800.00
24	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	785,192,900.00	760,079,800.00
25	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	95,576,356,130.48	69,173,301,394.90
26	УРСГАЛ ЗАРДАЛ	95,576,356,130.48	69,173,301,394.90
27	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	745,111,687.42	721,354,725.13
28	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,633,801.00	549,265,899.10
29	Үндсэн цалин	404,931,554.00	407,685,955.10
30	Нэмэгдэл	112,496,247.00	113,631,944.00
31	Унаа хоолны хөнгөлөлт	19,566,000.00	19,308,000.00
32	Урамшуулал	8,640,000.00	8,640,000.00
33	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,984,030.20	72,049,624.95
34	Тэтгэврийн даатгал	54,662,321.52	49,851,135.51
35	Тэтгэмжийн даатгал	3,108,770.92	5,547,821.12
36	ҮОМШӨ-ний даатгал	2,485,109.03	4,438,256.90
37	Ажилгүйдлийн даатгал	610,753.66	1,109,564.22
38	Эрүүл мэндийн даатгал	6,117,075.07	11,102,847.20
39	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,394,743.37	28,878,500.00
40	Гэрэл, цахилгаан	4,250,000.00	3,950,000.00
41	Тулш, халаалт	23,113,000.00	23,113,000.00
42	Цэвэр, бохир ус	2,031,743.37	1,815,500.00
43	Хангамж, бараа материалын зардал	28,087,049.71	26,906,657.85
44	Бичиг хэрэг	5,716,400.00	6,016,400.00
45	Тээвэр, шатахуун	12,473,300.00	12,473,300.00
46	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,471,149.71	2,671,757.85
47	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	814,000.00
48	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,076,200.00	4,931,200.00
49	Эд хогшил, урсгал засварын зардал	1,333,400.00	2,670,100.00
50	Багаж, техник, хэрэгсэл	1,126,100.00	1,670,100.00
51	Урсгал засвар	207,300.00	1,000,000.00
52	Томилолт, зочны зардал	2,292,500.00	1,834,700.00
53	Дотоод албан томилолт	2,292,500.00	1,834,700.00
54	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,136,163.14	37,475,121.23

55	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,570,808.48	26,079,600.00
56	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
57	Даатгалын үйлчилгээ	630,510.00	650,000.00
58	Тээврийн хэрэгслийн татвар	78,100.00	79,500.00
59	Газрын төлбөр	20,650.00	20,650.00
60	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,326,210.00	6,677,860.00
61	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,509,884.66	967,511.23
62	Бараа үйлчилгээний бусад зардал	1,250,000.00	2,274,122.00
63	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,250,000.00	2,274,122.00
64	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,831,244,443.06	68,451,946,669.77
65	Бусад урсгал шилжүүлэг	57,091,994,200.08	60,226,464,562.89
66	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	56,944,209,745.00	60,179,427,217.14
67	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,384,166.00	11,597,300.00
68	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	109,758,589.08	35,440,045.75
69	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,641,700.00	0
70	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,739,250,242.98	8,225,482,106.88
71	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,739,250,242.98	8,225,482,106.88
72	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,970,039,559.59	469,609,707.16
73	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,970,039,559.59	469,609,707.16
74	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,506,317,319.14	6,476,356,878.73
75	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,476,356,878.73	6,945,966,585.89

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	3,195,902,547.32	3,491,016,852.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	20,060,909.00	20,060,909.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	3,215,963,456.32	3,511,077,761.21
4	Тайлант үеийн үр дүн	0	0	7,346,227,677.20	7,346,227,677.20
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	10,562,191,133.52	10,857,305,438.41
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	10,562,191,133.52	10,857,305,438.41
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	10,562,191,133.52	10,857,305,438.41
8	Тайлант үеийн үр дүн	0	0	1,334,971,071.42	1,334,971,071.42
9	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	284,367,256.89	10,747,048.00	11,897,162,204.94	12,192,276,509.83

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,506,170,300.00	60,908,636,631.04	0.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	61,506,170,300.00	60,908,636,631.04	0.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,003,700.00	719,932,113.90	0.00
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	582,861,300.00	549,265,899.10	0.00
5	Үндсэн цалин	434,591,500.00	407,685,955.10	0.00
6	Нэмэгдэл	117,242,600.00	113,631,944.00	0.00
7	Унаа хоолны хөнгөлөлт	22,387,200.00	19,308,000.00	0.00
8	Урамшуулал	8,640,000.00	8,640,000.00	0.00
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,772,300.00	72,049,624.95	0.00
10	Тэтгэврийн даатгал	52,457,800.00	49,851,135.51	0.00
11	Тэтгэмжийн даатгал	5,828,600.00	5,547,821.12	0.00
12	ҮОМШӨ-ний даатгал	4,662,900.00	4,438,256.90	0.00
13	Ажилгүйдлийн даатгал	1,165,700.00	1,109,564.22	0.00
14	Эрүүл мэндийн даатгал	11,657,300.00	11,102,847.20	0.00
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,878,500.00	28,878,500.00	0.00
16	Гэрэл, цахилгаан	3,950,000.00	3,950,000.00	0.00
17	Түлш, халаалт	23,113,000.00	23,113,000.00	0.00
18	Цэвэр, бохир ус	1,815,500.00	1,815,500.00	0.00
19	Байрны түрээс	0.00	0.00	0.00
20	Хангамж, бараа материалын зардал	26,906,700.00	26,906,657.85	0.00
21	Бичиг хэрэг	6,016,400.00	6,016,400.00	0.00
22	Тээвэр, шатахуун	12,473,300.00	12,473,300.00	0.00
23	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,671,800.00	2,671,757.85	0.00
24	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	814,000.00	814,000.00	0.00
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,931,200.00	4,931,200.00	0.00
26	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00	0.00
27	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	1,500,000.00	0.00
28	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	0.00
29	Томилолт, зочны зардал	1,834,700.00	1,834,700.00	0.00
30	Дотоод албан томилолт	1,834,700.00	1,834,700.00	0.00
31	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,250,200.00	36,507,610.00	0.00
32	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,080,100.00	26,079,600.00	0.00
33	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00
34	Даатгалын үйлчилгээ	650,000.00	650,000.00	0.00
35	Тээврийн хэрэгслийн татвар	79,500.00	79,500.00	0.00
36	Газрын төлбөр	20,700.00	20,650.00	0.00
37	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8,419,900.00	6,677,860.00	0.00
38	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,989,122.00	0.00
39	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,989,122.00	0.00
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,747,166,600.00	60,188,704,517.14	0.00
41	Бусад урсгал шилжүүлэг	60,747,166,600.00	60,188,704,517.14	0.00
42	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	60,737,889,300.00	60,179,427,217.14	0.00
43	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,277,300.00	9,277,300.00	0.00
44	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,506,170,300.00	31,761,141,083.00	0.00
45	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,290,026,700.00	47,194,200.00	0.00
46	Улсын төсвөөс санхүүжих	9,290,026,700.00	47,194,200.00	0.00
47	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	52,216,143,600.00	31,645,231,194.63	0.00
48	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	52,216,143,600.00	31,645,231,194.63	0.00
49	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	68,715,688.37	0.00
50	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	68,351,688.37	0.00
51	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	364,000.00	0.00
52	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,476,356,878.73	0.00
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	6,945,966,585.89	0.00
54	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	95.00	95.00	95.00
55	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00
56	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00
57	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47.00	47.00	47.00
58	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00
59	Гүйцэтгэх ажилтан	40.00	41.00	41.00
60	Үйлчлэх ажилтан	6.00	5.00	5.00
61	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47.00	47.00	47.00
62	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	41.00	41.00	41.00

Байгууллагын нэр: Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	455100
2	УРСГАЛ ЗАРДАЛ	455100
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455100
4	Эд хогшил, урсгал засварын зардал	170100
5	Багаж, техник, хэрэгсэл	170100
6	Бараа үйлчилгээний бусад зардал	285000
7	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	285000
8	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	455100
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	455100
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285000
11	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170100